



# Хууль Зүйн Яам

## Эрх Зүйн Мэдэгдэл

### ЭРҮҮГИЙН БАЙЦААЛТЫН ХУУЛИЙН 706-73 ЗҮЙЛИЙН ДАГУУ 16 НАСНААС ДЭЭШ НАСТАЙ НАСАНД ХҮРЭЭГҮЙ ИРГЭН НАСАНД ХҮРСЭН НЭГЭНТЭЙ ХАМТАРЧ ЭСВЭЛ ТҮҮНТЭЙ ХУЙВАЛДАЖ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ТҮР ХОРИОНД ОРСОН ТОХИОЛДОЛД ГАРДУУЛАХ

**Доорх мэдээллүүдийг таны ойлгох хэл дээр бичиж танд өгсөн байх шаардлагатай.**

**Хэрвээ мэдээлэл нь таны дээд ашиг сонирхолыг хөндөөгүй эсвэл шүүхийн үйл ажиллагаанд хор хөнөөлтэй биш бол эцэг эхийн эрх эдэлж буй хүмүүс үүнтэй ижил мэдээлэл авах болно.**

**Та энэ баримт бичгийг хоригдох хугацаандаа хадгалах эрхтэй.**

Таныг шоронд орох ял шийтгэл хүлээх ямарваа нэгэн гэмт хэргийг насанд хүрсэн хүнтэй хамтарч эсвэл түүнтэй хуйвалдаж үйлдсэн эсвэл үйлдэхийг завдсан болох хэрэгт сэжиглэх нэг эсвэл хэд хэдэн шалтгаан байгаа учраас таныг түр хорионд оруулж саатуулсан тухай танд мэдээлсэн.

Та өөрийнхөө түр хоригдох болсон зөрчлийн утга шинж, огноо ба байрлалыг мэдэх бүрэн эрхтэй болон өөрийг тань түр хорих болсон тодорхой шалтгаануудтай танилцах эрхтэй.

24 цагийн хугацаатай үргэлжлэх түр хорионы үеэр таны үйлдсэн хэргийн дагуу таныг байцаах болно.

Энэ хугацааны эцэст Улсын прокурор (анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрх хариуцсан шүүгч) таны түр хорих хугацааг дахин 24 цагаар үргэлжлүүлэн сунгах эсэхийг шийдэх эрхтэй. Та шүүх хуралд оролцоно үгүй бол видео шүүх хуралд оролцоно.

Онцгой тусгай тохиолдолд хэрвээ мөрдөн байцаалт эсвэл зааварчилгааны дагуу түр хориог нэмэлт 24 цагаар хоёр удаа сунгалт хийж болно, тус бүр 24 цагийн хугацаатай, үүнийг эрх чөлөө олгох ба түр хорио олгохыг шийдэх шүүгч эсвэл анхан шатны шүүгч шийднэ.

Гэсэн хэдий ч мөрдөн байцаалтын урьдчилсан таамаглах боломжтой хугацааг 48 цагийн дотор батлан гүйцэтгэх нь батлагдсан тохиолдолд эрх чөлөө олгох ба түр хориог шийдэгч шүүгч нь Улсын прокурорын хүсэлтээр, эсвэл анхан шатны шүүгч нь түр хориог зөвхөн ганц удаа 48 цагаар сунгаж болно.

Энэ түр хорионы эцэст Улсын прокурорын эсвэл анхан шатны шүүгчийн шийдвэрийн дагуу таны хэргийг захиргааны шүүхэд хэрэг нээж шийдвэрлүүлэх боломжтой эсвэл таныг суллан чөлөөлж болно. Эхний тохиолдолд та тэр өдөр шүүх хуралд оролцоно. Хэрвээ хууль зүйн байгууллага зохих байдлаар тоногдсон хорих байртай ба мөн таны түр хорио 72 цагаас хэтрэхгүй хугацаатай байвал та түр хорионы төгсгөлөөс 20 цагаас хэтрэлгүй хугацаанд дараагийн өдөр шүүх хуралд оролцох болно. Хэрвээ таны түр хорио 72 цагаас илүү давсан хугацаатай бол таны шүүх хуралд орж хэргээ шүүгчээр шийдүүлэх нь түр хорио дуусах өдөрт ноогдоно.

**Үүнээс гадна та доор дурдсан эрхтэй:**

#### **Зарим хүмүүст мэдээлэл хүргэх**

Таны эцэг эхэд эсвэл таны асран хүмүүжүүлэгч, эсвэл таныг хариуцсан хүмүүжүүлэгчид зайлшгүй таныг түр хорионд орсны тухай мэдэгдэх ба үүний зэрэгцээ үйлдсэн хэргийн шинж байдал, огноо ба үйлдсэн хэргийн байрлалын тухай мэдэгдэх болно.

Та хамт амьдардаг хүмүүсийг эсвэл эцэг эхийнхээ аль нэгийг эсвэл ах эгчийнхээ аль нэгийг, эсвэл өөрийнхөө куратор эсвэл өөрийн хүмүүжүүлэгчдээ түр хорионд орсон арга хэмжээний тухай утсаар ярьж мэдүүлэхийг хүсэх эрхтэй.

Та мөн өөрийн ажил олгогчдоо энэ мэдээг хүргэж болно.

Хэрвээ та гадаад улсын иргэн бол та өөрийн улсын консулын газарт үүний тухай мэдээлж болно.

Даван гарах боломжгүй байдлуудаас бусад тохиолдлуудад шүүгчид өргөдөл гаргасан хугацаанаас 3 цагаас хэтрэхгүй хугацаанд яаралтай байдлаар уг хэрэгт оролцоно.

Улсын прокурор (анхан шатны шүүгч нь, эсвэл хүүхдийн эрхийн шүүгч) цуглуулах зайлшгүй шаардлагатай эсвэл амь насанд, эрх чөлөөнд эсвэл хэн нэгний бие махбодид халдсан нотолгоо цуглуулахад шаардлагатай бол саналуудыг хойшлуулах эсвэл хүргэх боломжгүй зэргийг шийдэх эрхтэй. Таны хууль зүйн төлөөлөгчдийн санал бодлын тайланг хэрвээ түр хорих арга хэмжээг сунгах бол 24 цагаас хэтрэхгүй байх, үгүй бол арван хоёр цагаас хэтрэхгүй авна.

Хэрвээ таны түр хорио 48 цагаас илүү хугацаагаар сунгагдсан тохиолдолд эрх чөлөө ба түр хорио олгох шүүгч (эсвэл анхан шатны шүүгч) нар таны ойр дотны хүмүүс ба таны ажил олгогчийн саналыг хадгалах боломжтой.

### **Хэн нэгэнтэй холбоо барих**

Та өөрийнхөө түр хорионд орсон тухай мэдэгдэх шаардлагатай хэн нэгэнтэй захидал бичгээр эсвэл утсаар ярьж холбогдон харилцаж болно.

Шүүхийн цагдааны хэлтэсийн албан хаагч хэрвээ уг хүсэлт таны хоригдох болсон хэргийн шалтгаануудтай тохирохгүй байх, эсвэл үүнээс үүдэж аливаа нэгэн зөрчил үүсэх эрсдэл байгаа гэж үзсэн тохиолдолд таны хүсэлтийг хүлээн авахгүй байж болно. Тэр энэ уулзалтын үргэлжлэх хугацааг түүний эсвэл өөр нэгэн албан хаагчийн хяналтан дор 30 минут үргэлжлэхийг тодорхойлох болон уулзалтын нөхцөл байдал, огноо цаг өдөр зэргийг тодорхойлно.

Хэрвээ таны түр хорио 48-аас илүү хугацаагаар үргэлжлэх тохиолдолд шүүхийн цагдааны албан хаагч таны консулын газрын төлөөллүүдтэй холбогдохоор таны гаргасан хүсэлтэд татгалзах эрхгүй.

### **Эмчийн үзлэгт хамрах**

Хоригдох хугацааны эхнээс эхлэн та түр хориог сунгасны улмаас дахин давтан эмчийн үзлэгт хамрах хүсэлт гаргаж болно. Хэрвээ таныг түр хорих хугацааг 48 цагаас илүү хугацаатай сунгасан тохиолдолд та зайлшгүй эмчийн үзлэгт орох шаардлагатай ба танд дахин эмчийн үзлэгт орох эрхтэй болохыг танд зөвлөнө. Энэ хүсэлтийг таны эцэг эх, таны асран хүмүүжүүлэгч эсвэл байгууллагаас таныг итгэмжилсэн хүн мөн адил гаргаж болно.

Таны өмгөөлөгч таныг эмчийн үзлэг хамруулах хүсэлт гаргах эрхтэй.

### **Мэдэгдэл хийх, асуултанд хариулах эсвэл үг хэлэхгүй байх**

Биеийн байцаалтаас татгалзсан бол та шүүх хурлын үед доорх эрхтэй:

- мэдэгдэл гаргах,
- таниас асуусан асуултуудад хариулах,
- үг хэлэхгүй байх.

### **Хууль зүйн төлөөлөгчтэй хамт хүрэлцэн ирэх**

Хэрвээ зохих мэргэжлийн байгууллага зайлшгүй шаардлагатай гэж үзвэл та шүүх хуралд эсвэл байцаалтад эцэг эхийн талын хариуцлага хүлээсэн иргэд болон төлөөлөлтэй хамт хүрэлцэн ирж болно. Үгүй бол та хэн нэгэн өөр насанд хүрсэн хүнийг тантай хамт хүрэлцэн ирэхийг хүсэх эсвэл шүүхийн байгууллагаас томилсон насанд хүрсэн хүнтэй хамт хүрэлцэн ирнэ.

### **Өмгөөлөгчийн туслалцаа авах**

**Та заавал өмгөөлөгчийн туслалцаа авна.**

### **Өмгөөлөгчийн сонголт**

Түр хорио эхлэснээс эхлэн шүүх хурлын аливаа нэгэн мөч хүртэл түр хорих хугацаа сунгасан тохиолдолд сунгалтын эхэнд та өөрийн сонголтоор өмгөөлөгчийн туслалцаа нэхэх эрхтэй. Хэрвээ та өмгөөлөгч авч чадахгүй эсвэл өмгөөлөгчтэй холбоо барих боломжгүй бол, шүүхийн цагдаагийн хэлтэсийн ажилтан эсвэл Улсын прокурор (анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрхийн шүүгч) танд туслуулахаар өмгөөлөгч томилж өгнө.

Таны өмгөөлөгчийг таны эцэг эх, эсвэл асран хүмүүжүүлэгч эсвэл таныг хариуцаж байгаа албаны ажилтан томилж болно.

### **Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцооны хугацаа**

Өмгөөлөгч нь ярилцлагын нууцыг хадгалсан нөхцөл байдалд тантай 30 минутын хугацаанд ярилцах эрхтэй; түр хорих хугацааг сунгасан тохиолдолд та өмгөөлөгчтэйгөө дахин уулзах хүсэлт дахин гаргаж болно.

Үүний зэрэгцээгээр хэрвээ та хүсэлт гаргавал таны маргаан, шүүх хуралд оролцох, таны үйлдсэн үйлдлүүдийг давтах, үйлдүүдийг тодорхойлох хэрэгт тэр оролцох эрхтэй.

Энэ тохиолдолд таны анхны шүүх хурал, таны биеийн байцаалт дээр зөвхөн тулгуурлаж байгаа тохиолдлоос бусад тохиолдолд, өмгөөлөгчгүйгээр шүүхийн ажиллагаагааны хүсэлт гаргаснаас 2 цагийн хугацаа өнгөрөөгүй байхад эхлэхгүй. Гэсэн хэдий ч хэрвээ мөрдөн байцаалт үүнийг шаардаж байвал таны анхны шүүх хурал таны өмгөөлөгчийн эзгүйд ч гэсэн Улсын прокурорын зөвшөөрлөөр (анхан шатны шүүгчийн хүсэлтээр) тэр дороо эхэлж болно.

Хэрвээ таны өмгөөлөгч шүүх хуралд оролцож байхад ямарваа нэгэн маргаан үүсвэл шүүх хурал таны хүсэлтээр таныг өмгөөлөгчтэй ярилцуулах зорилгоор түр завсарлаж болно.

Улсын прокурор, анхан шатны шүүгч эсвэл хорих эрх чөлөөний шүүгч гэнэтийн шалтгаанаар маш онцгой гойд тохиолдолд таны өмгөөлөгчийн таны шүүх хуралд оролцох туслалцааг, хэрвээ таван жилд шоронгийн ял эдэлсэн бол, дээд хэмжээгээр 12 цагаар, нэг удаа шинэчлэх эрхтэйгээр хойшлуулан түдгэлзүүлж болно.

### **Хэлмэрчийн туслалцаа авах**

Хэрвээ та франц хэлээр ярьдаггүй ба ойлгодоггүй бол та шүүх хурлуудынхаа үеэр болон өмгөөлөгчтэйгөө харилцахаар үнэ төлбөргүй хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

### **Түр хориог эцэслэх хүсэлт гаргах**

Та Улсын прокурорт эсвэл анхан шатны шүүгчид хандаж эсвэл хүүхдийн эрхийн шүүгчид хандаж шүүх энэхүү түр хорих хугацааг сунгах шийдвэр гаргасан тохиолдолд сунгахгүй байх хүсэлт гаргахаар хандах эрхтэй.

### **Хэргийн хэсгүүдтэй танилцах**

Таны хүсэлтээр эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та өөрийн түр хориог сунгахын өмнө доорх байдлуудтай танилцах эрхтэй:

- таныг түр хорионд оруулах тухай протоколын мэдэгдэл;
- таныг үзсэн эмчийн гаргасан эрүүл мэндийн гэрчилгээ эсвэл гэрчилгээнүүдтэй танилцах,
- шүүх хурлуудын протоколүүдтай танилцах эрхтэй.

### **Улсын прокурорт танилцуулах**

Түр хорионы эцэст та нэг жилийн хугацаанд Улсын прокурорт баталгаатай захидлаар эсвэл нотариатын нотолгоотой итгэмжлэлээр өөрийн танилцуулгыг боловсруулах зорилгоор өөрийнхөө хэрэгтэй танилцах мэдэгдэл гаргаж болно.

### **Хувийн нууцлалын эрх**

Энэхүү арга хэмжээнд таны оролцсон шүүх хурлуудыг видео хальсанд бичлэг хийх тохиолдлууд орно. Энэ бичлэгүүдийг хэн нэгэнд үзүүлэхийг хориглодог.

Бичлэгүүдийг хаалттай нөхцөлд зохих мэргэжилтэн хүмүүст үзүүлж болох ба үүний улмаас шүүх хурлын ярилцлагын тайлагналыг нийтлэхийг хориглодог ба таныг тодорхойлох бүх хэсгүүдийг үзүүлэхийг хориглодог.